



# СОЁМБОМ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

№52 /266/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.03.16

## “МОНГОЛ ЦЭРГИЙН ӨДӨР”, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 101 ЖИЛИЙН ОЙН БАЯРЫН МЭНД ДЭВШҮҮЛЬЕ!

### У.Хүрэлсүх: ЖАГСААЛЫН ДАРГА, БАГА ДАРГА НАР ЗОЛБОО ХИЙМОРЬ, ҮЛГЭРЛЭЛ, УР ЧАДВАРЫН ЭЗЭД БАЙДАГ

“Монголцэргийнөдөр”, орчинцагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 101 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүх, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, УИХ, Засгийн газрын гишүүн, Хууль зүй, Дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумьяабаазар, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогын зөвлөх дэслэгч генерал Ц.Тогоо, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дэд дарга Б.Энх-Амгалан, ЗХЖШ-ын дарга дэслэгч генерал Д.Ганзориг, ОБЕГ-ын дарга хошууч генерал Г.Аруинбуян нарын хүндэт зочдоос гадна төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудад алба хааж байсан жагсаалын дарга, бага дарга нар оролцож байна.

Хүндэтгэлийн арга хэмжээнд Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүх, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, УИХ, Засгийн газрын гишүүн, Хууль зүй, Дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумьяабаазар, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогын зөвлөх дэслэгч генерал Ц.Тогоо, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дэд дарга Б.Энх-Амгалан, ЗХЖШ-ын дарга дэслэгч генерал Д.Ганзориг, ОБЕГ-ын дарга хошууч генерал Г.Аруинбуян нарын хүндэт зочдоос гадна төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудад алба хааж байсан жагсаалын дарга, бага дарга нар оролцож байна.

“Цэргийн андууд” дурсамж уулзалтыг Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх нээж хэлсэн үгэндээ “Монгол цэргийн ялан дийлэх арга ухааны ох нь болсон дайчин бат нөхөрлөл, дарга, цэргийн амьд холбоог дархлан бэхжүүлэхэд Монгол цэргийн аравтын даргаас эхтэй тасгийн захирагч, салааны захирагчийн орлогч, жагсаалын дарга гээд бага дарга, түрүүч нар онцгой үүрэг гүйцэтгэж ирсэн билээ. Тэд цэрэг дайчдын дотнын зөвлөгч, хүмүүжүүлэгч нь төдийгүй, шадар захирагч нь, офицерын бүрэлдэхүүний найдвартай түшиг тулгуур, цэрэг дайчидтайгаа холбогдох амин судас нь болж байдаг юм. Цэрэгт хаана шилдэг сайн бага дарга нар байна тэнд сахилга чанд, сургалт бэлтгэл чамбай, амжилт бүтээл арвин байдгийг бид бүхний ажил амьдралын түүх гэрчилнэ.

Жагсаалын дарга, бага дарга нар золбоо хийморь, үлгэрлэл, ур чадварын эзэд байж, аливаа эрдэмд шамдан суралцаж, сахилга, дэг журмыг чандлан сахиж, тэсвэр хатуужилтай, эмх цэгцтэй, нөхөрлөлдөө үнэнч байх зэрэг эрхэм чанарыг төгс эзэмшсэн, амьдралд нугардаггүй, бэрхшээлд шантардаггүй, жаргалд ташуурдаггүй, зовлонд гунддаггүй манлайлагчид байдаг.

Ийм ч учраас цэргийн алба хаасан хүн бүрийн зүрх сэтгэлд насан туршид нь хадгалагдаж үлддэг хамгийн нандин



дурсамж бол цэргийн хүн болсныг нь ухааруулж, жагсаалд эзлэх байрыг нь зааж, баруун зүүнээ олох, алхах гишгэхийг биелчлэн сургаж “Цэргийн эрдмийн цагаан толгойг” зааж, аливаад үлгэрлэн манлайлж байсан жагсаалын дарга, бага дарга нарын тухай дурсамж байдаг юм.

Монголын ард түмэн цэргийн албыг эрдмийн алба, иргэний төлөвшил, тэсвэр хатуужлын сургууль хэмээн үнэлдэг. Цэргийн албанд манлайлагчид, үлгэрлэн дагуулагч байсан бага даргын эрхэм чанар насан туршид нь ажил алба, амьдралд нь мөрдөх хэвшил, зуршил, хэм хэмжээ нь болдог.

Монгол цэргийн бага дарга нараас Монгол Улсын 10 гаруй баатар, төр, нийгмийн зүтгэлтэн, хөдөлмөрийн сайчууд, урлаг соёл, спортын алдартан-ардын болон гавьяат цолтон, хамт олон, нутаг усныхандаа ноён нуруу, эмх цэгц, төлөв төвшнөөрөө үлгэрлэгчид олноороо төрөн гарсныг бид мэднэ.

Цэрэгт манлайлагчид байсан, цэрэг олон түмний шадар дарга байсан нэр нөлөө бүхий эрхмүүдийн сайн

дурын эвлэлдэн нэгдсэн “Бага дарга нарын холбоо” нийгэмд хошуучлагч байж, Монгол Улсын язгуур эрх ашгийг ямагт эн тэргүүнд тавин, монгол хүний хөгжил, эв оронч ухамсар, хандлага, монгол ахуй, эх соёл, зан заншлыг хойч үедээ өвлүүлэхэд үнэтэй хувь нэмрээ оруулна гэдэгт би итгэлтэй байна.


Саяхан зохион байгуулагдсан “Нийгмийн хөгжилд эрэгтэйчүүдийн оролцоо, манлайлал” Үндэсний чуулганд Монгол Улсын Ерөнхийлөгч миний бие оролцож үндэстнийхээ аюулгүй байдал, Монгол гэр бүлийн сайн сайхан амьдралын төлөө “Эрүүл Монгол Хүн” үндэсний хөдөлгөөнийг өрнүүлж, өнөөгийн Монголын нийгэмд гарч буй төрөл бүрийн гэмт хэрэг зөрчил, хүчирхийллийн эх үүсвэр болсон архидалттай тэмцэхийг уриалаад байна. Энэхүү уриалгыг бүх талаар дэмжиж эх орон даяар манлайлан оролцохыг дайчин нөхөд Та бүхнээс хүсье.

Эрхэм бага дарга нар, түрүүч байлдагчид та бүхэнд Монгол цэргийн өдөр, орчин үеийн Зэвсэгт хүчин үүсэж байгуулагдсаны 101 жилийн ойн баярын мэндийг дэвшүүлж, чин сэтгэлийн халуун

баяр хүргэж, Монгол төрийн сүлд хийморь өнө мөнхөд ивээж явахын өлзийтэй ерөөлийг өргөн дэвшүүлж

гэлээ. “Амрыг эрье” хэмээн уулзалдаж буй эдгээр цэргийн гэх тодотголтой жагсаалын дарга, бага дарга нар ийнхүү нэг өдөр цэргийн алба хааж байсан дурсамжаа хуваалцан байна.

Дурсамж уулзалтын хүрээнд Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын музейн үзэсгэлэнгүүд дэлгэгдэж, ЦДБЭЧ, Цагдаагийн “Сүлд” чуулга, ХЦДБЭЧ-ын уран бүтээлээс гадна ЗХЖШ-ын УЖҮНХ, Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн Хүндэт харуулын тусгай ротын дайчдын болон УБХИС-ийн “Тэмүүжин Өрлөл” сургуулийн сурагчдын жагсаалын үзүүлэх тоглолтоор ирсэн зочдын сэтгэлийг баясаж, дурсамж уулзалтын үйл ажиллагааг улам төгөлдөр болгожээ. Мөн Үндэсний урлагийн их театр, Төрийн соёрхолт “Харанга”, “Хурд”, “Никитин” хамтлагууд болон Монгол Улсын Гавьяат жүжигчин Т.Ариунаа нарын цэрэг эх орны сэдэвт уран бүтээл баяр дээр баяр нэмэх ажээ.



## “МЭДЛЭЭ, ГҮЙЦЭТГЭЭ” ГЭЭД Л АЖИЛДАА ОРСОН ДОО

Монголын бага дарга нарын холбооны тэргүүн Р.ДАГВА /1984-1987 оны хугацаат цэргийн алба хаагч, жагсаалын дарга/

Монголын бага дарга нарын холбоо хэрхэн үүсэн байгуулагдав? Үйл ажиллагааны үндсэн чиглэл нь юу вэ?

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний командлагч У.Хүрэлсүх бид хоёр онжавууд юм л даа. 2019 оны 5 дугаар сард тэрбээр Ерөнхий сайд байхдаа Монголын жагсаалын дарга нар буюу Жа нарын холбоо гэж байж болох талаар саналаа хэлж, ажил хэрэг болгоод, үйл ажиллагааг нь жигдрүүлэх чиглэл өгсөн. Миний бие тухайн үед Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга байлаа. Гурван жилийн албыг жагсаалын дарга, ахлах түрүүч цолтой хаасны хувьд “Мэдлээ, гүйцэтгээ” гээд л ажилдаа орсон доо. Тэгээд хамгийн түрүүнд хамт алба хааж байсан Ховдын хорооны нөхдөө дуудаж цуглуулсан. Ингээд холбооны маань үйл ажиллагаа жилээс жилд өргөжин тэлсээр өнөөдөр 21 аймаг, 9 дүүрэгт салбартай, 17 мянга орчим гишүүнтэй нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага боллоо. Жагсаалын дарга гэхээр бас цагаа тулахаар цөөхөн байсан. Манай Ховдын хороо гэхэд л мотобудлагын гурван батальон, их бууны



дивизион гээд 1000-аад цэрэгтэй атлаа

40, 50 жагсаалын дарга байх жишээтэй. Тэгэхээр нь зөвхөн жа нараар тогтохгүй бага дарга нарыг хамруулахаар шийдсэн нь өнөөдөр ийнхүү өргөжин тэлэхийн үндэс болсон. Ер нь цэргийн алба хаасан хүн цаанаасаа л жавхаатай, цэргийн дүрмээр бие нь цэгцэрсэн, айл гэрийг аваад явчих ухаан суусан, аливаад тэсвэр хатуужилтай, хүний үг даадаг, ер нь л жинхэнэ эр хүний хугархай болдог шүү дээ. Армид алба хаасан, ялангуяа жагсаалын дарга байсан хүн ямагт бусдыгаа манлайлж, бусдын өмнөөс хариуцлага хүлээж, цэргүүдийнхээ аав, ах нь, халамжлан хүмүүжүүлэгч нь юм шиг харьцдаг.

Манай холбоо жагсаалын дарга, бага дарга байсан хүмүүсийнхээ холбоо харилцааг сэргээх, амьдрал ахуйг дэмжих, урам зориг өгөх, цэргийн албаа дурсан санах боломжийг олгох, нийгэмд сайн үлгэр дуурайлал үзүүлэх зорилготой. Мөн өнөөгийн

өөрийгөө хэрхэн зөв авч явах, бусдыг манлайлах, хариуцлагатай, ёс зүйтэй байх, эр хүн байхын мөн чанар, агуулгыг ойлгуулахыг зорьдог. Тэдэнд эх орноо батлан хамгаалах үйлсийг сурталчлах, эр цэргийн алба хаахын ач холбогдлыг ойлгуулах, тэндээс насан туршийн эрчүүдийн сайхан нөхөрлөл эхэлдгийг ойлгуулахыг хичээдэг. Бид нийслэл, дүүрэг, аймаг, сумдын бүх Цэргийн штабынхантайгаа холбоотой байж, нягт хамтарч ажилладаг. Тэд ч ясны цэрэг хүний хариуцлагатай, хэлсэндээ хүрдэг, ажил хэрэгч чанарыг үнэлдэг болоод тэр үү бидэнтэй хамтарч ажиллах дуртай байдаг.

Эрчүүд цэргийн алба хааснаа насан туршийн бахархал болгон ярьцгаадаг. Одоо бүр нэгдсэн холбоо, олон нийтийн байгууллагын зохион байгуулалтад орохоор бүр таатай байгаа байх даа.

Тийм ээ, Нэг жишээ хэлье л дээ. Бид Багануурт нэг жагсаалын даргыг сурагласаар яваад очлоо. “Амрыг эрье” гээд уулзахад нэг их гайхсан харцаар хүлээж авсан. Бид түүний алба хааж байсан анги, цол, овог нэрийг нь хэлээд ийм холбоо байгуулсан, бүртгэж явна гэхэд нөгөөх маань шууд уйлаад эхэлсэн.

(Үргэлжлэл нь II нүүрт)

**БИЕ БЯЛДАР, БИЛЭГ ОЮУНАА ЗЭРЭГ ХӨГЖҮҮЛСЭН**



**Архангай аймгаас хүрэлцэн ирсэн бага дарга, ахлах түрүүч Т.Оюунтан:**  
Хүсэл мөрөөдлөөр жигүүрлэсэн 19 настай залуу Архангай аймгаас нийслэл хотод цэрэгт татагдан ирж, 1968-1971 онд Улиастайн инженер сапёрын тусгай батальон буюу Ардын Армийн 014 дүгээр ангид гурван жил алба хаагаад Ардын хувьсгалын 50 жилийн ойгоор халагдаж байлаа. Хоёр сар болоод ротын бичээчээр томилогдсоноос хойш ангийн нууцын албаны бичээч хүртэл

хийж байгаад халагдсан. Бичгийн хүн гээд цэргийн хэргийн мэдлэг, дадлага сургуулилтаас чөлөөлөгдөнө гэсэн ойлголт байхгүй учир бие бялдар, билэг оюунаа зэрэг хөгжүүлсэн. Цэргийн гурван жилд хүн жинхэнэ эр болж төлөвшинэ, цэргийн эрдэмд суралцана, хамт олон дунд биеэ авч явна, хүмүүстэй харьцаж сурна, сайхан шүү. Цэрэг эх оронч үзэл, хүмүүжил утгаараа цэргийн хуаранд өрнөнө. Цэргийн албанд ах дүүс, анд нөхдөрөө үдүүлж, албаа нэр төртэй хаагаад ирэхэд аав

ээж шинэ гэр орон бэлдчихсэн "Гэргий хүүхнээ аваад ир" гэж утгасан. Цэргээс ирсэн залуучуудад ажлын байр ч бэлэн байдаг байлаа. Цэргийн албаа хааснаас хойш 52 жил өнгөрчээ. Онжавууд минь 70 гарсан буурлууд байна даа. Хүний орчлонгийн жамаар цөөрөх юм аа, бас. Цэргийн амьдрал надад маш сайхан нөлөө, үгэр дууриалал үзүүлсэн. Өнөөдөр 74 настай ахмад бид алха дуртай, даралт бол яг нормдоо, элдэв хууч өвчингүй явна. Энэ цэргийн алба хаасны л гавьяа шүү дээ.

**ОДОО Ч БИЕ БИЕНЭЭ ЖА, ОНЖАВ АА, САЛААН ОРЛОГЧ ОО, ТҮРҮҮЧ ЭЭ Л ГЭДЭГ**



Дундговь аймгийн харьяат хорооны эмнэлгийн зааварлагч, түрүүч Р.Энхбаяр, Танкийн батальоны III ротын жагсаалын дарга ахлах түрүүч С.Өлзийсайхан, I батальоны I ротын жагсаалын дарга ахлах түрүүч Ц.Ганхуяг, ахлах түрүүч А.Батзориг нар Өмнөговь аймаг дахь Мотобуудлагын хороо буюу Ардын Армийн 167 дугаар ангид цэргийн алба хаасан Жа нар гэнэ. "Цэргийн андууд" дурсамж уулзалтын анхныхад оролцож байсан Ц.Ганхуяг энэ жил онжавуудаа дагуулан зорин иржээ. Цэргийн албанд очоод нутаг орныхоо нэрийг

өндөрт өргөж, хийморьтой явсан залуучууд маань 30 гаруй жилийн хугацаанд цэргийн андууд, онжавын нөхөрлөлөөр өнөөг хүртэл үерхэж, бүр гэр бүлийн найзууд болтлоо дотносчээ. Аав ээжийн гэрээс гарч, олны дунд орох анхны алхмаа хийж байгаа залуучуудын хувьд бүхий л зүйл онцгой, олон аавын хөвгүүдтэй мөр зэрэгцэж, хийморьлог албанд зүтгэн байсан тэр үе амьдралынх нь хамгийн дурсамжтай он жилүүд. Эрчүүдийн нөхөрлөл гэдэг ийм тууштай, үнэнч байдаг ажээ. Өмнөговийн Мотобуудлагын

хороо гэхэд 1200 цэрэгтэй, маш олон салбартай. Тэнд эх орныхоо өнцөг булан бүрээс нэг дор цугласан залуучуудад ам зэрех, үл ойлголцох зэрэг асуудал гарнаа. Нэгнүүтгээс очсон ч гэлээ эдэн дундаас л гэхэд Өлзийсайхан, Энхбаяр хоёр шинэ цэргийн 7 дахь хоног дээрээ зодолдож байсан гэдэг. Харин одоо бие биенээ үгүйлэх сайн найзууд болжээ. Нэг тогтооноос хооллож, нэгэн казармд унтаж, нэг хөдөлгөөнөө зэрэг хийж жигдэрсэн тэд одоо ч бие биенээ Жа, онжав аа, салаан орлогч оо, түрүүч ээ л гэдэг.

**ТАМСАГБУЛАГИЙН УЛААН ШУГАМЫГ ТАВЬЖ, БАРИЛЦАЖ БАЙЛАА**



**Сонгинохайрхан дүүргийн 37 дугаар хорооны иргэн, бага түрүүч Б.Намсрай:**  
Төрж өссөн Өвөрхангай аймгаасаа Дорнод аймаг дахь Барилгын цэргийн 030 дугаар ангид 1987-1989 онд алба хааснаас хойш 30 гаруй жил өнгөрчээ. Ээжтэйгээ хоёулаа амьдардаг байсан ч цэрэгт явна гэж зүтгэсээр байгаад л явсан даа. Энгийн амьдралаас

цэргийн амьдралд ороход маш гоё санагдаж байсан. Ер нь цэрэгт яваад ирсэн ах нар бие хаа нь жагсаж жигдэрсэн, хүнтэй харьцах харьцаа сайтай, жинхэнэ эр хүн шиг сайхан харагддаг байсан. Олны дунд явахад цэргийн алба хаасан хүн цаанаа л өөр шүү дээ. Ах нь барилгын цэрэгт алба хаахдаа Тамсагбулаг сумын улаан шугамыг тавьж, орон

сууцны байшин, гахай, тахианы байр барилцаж явлаа. Одоо Халхгол гэж том сум болчихсон байна. Одоо бүр шинэ Халхгол гээд төслөөр улам өргөн дэлгэр болсон байна лээ. Алба хааж байхдаа Халхын голын байлдаан болж байсан ор мөр, танк, онгоцны сэггийг үзэж сонирхохоос гадна Жуковын командын байрыг бахархан байж очиж байсан.

**АРМИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНЭЭС МӨНГӨН МЕДАЛЬ ХҮРТЭЖ БАЙВ**



**Увс Улаангом сумын харьяат Л.Даваадорж:**  
Ах нь "Цэргийн андууд" дурсамж уулзалтад анх удаагаа оролцож байна,

маш их сэтгэл догдолж, хоног тоолон хүлээж ирлээ. Манай аймгаас энэхүү сайхан үйл ажиллагаанд оролцох хүсэлтэй хүн олон байсан ч 1400 орчим километрийн

зайтай болохоор аргагүй үлдсэн шүү. Би 1987 онд Увс аймгаас хугацаат цэргийн албанд татагдаж, Налайхын 235 дугаар бригадын тусгай салааны Жа-гаар алба хаасан. Цэргийн алба эр хүнд сахилга бат, дэг журам, сэтгэн бодох хурд, авхаалж самбаа олгодог. Цэрэгт байхдаа би спортоор хичээллэж, Армийн аварга шалгаруулах гурван төрөлтийн тэмцээнээс мөнгөн медаль хүртэж байлаа. Өнөөдөр бүхий л талаар сэтгэл хангалуун амьдарч яваа нь Ардын Армидад хоёр жилийн алба хаасны гавьяа үр дүн гэж боддог оо. Дарга нар шинэ цэргийн карантинаас л бага дарга нараа нүдэлдэг юм байна лээ. Би гурван жилийн цэргийн албаны төгсгөл, хоёр жилийн цэргийн албаны хоёр дахь удаад алба хааж таарсан. Түүрүү оны хоёр жилийн цэргүүдийн үед жа болсондоо сэтгэл хангалуун байдаг. Анх очоод "Сэрээд" команд их хэцүү санагдаж байсан, жаахан унтах юм сан гэж эрхгүй бодогддог байсан шүү. Гэхдээ гурван сар болоход л сайхан жигдрээд ирсэн. Халагдахад явмааргүй л санагдаж байсан. Анд нөхөдтэйгээ тэврэлдээд, уйлалдаад л...Цэргийн андууд насан туршийн найзууд байдаг. Аймгийнхаа онжавуудтай байнга холбоотой байдаг.

**“МЭДЛЭЭ, ГҮЙЦЭТГЭЭ” ГЭЭД Л АЖИЛДАА ОРСОН ДОО**

**(Түрүүч нь I нүүрт)**  
Хэсэг уйлаад тайвширсныхаа дараа, "Өнөөдөр би энгийн сайхан амьдралаар амьдарч яваа ч цэргийн амьдрал, жагсаалын дарга байсныг минь сануулаад сураглаад ороод ирнэ чинээ зүүдэлсэнгүй явлаа. Армийн амьдралаа хааяахан гэр бүлдээ ярьдаг ч миний сэтгэл хөдлөлийн энд хүртэл ойлгож сонсдоггүй байсан, ямар сайхан юм бэ" гэж билээ. Цэргийн алба хааж байсан үеийн дурсамж, үйл явдал бол бидний амьдралд хэзээ ч мартагдахааргүй маш сайхан дурсамжийг үлдээдэг юм гэдгийг үүнээс мэдэрч болно. **Холбооны зүгээс энэ хугацаанд нийгэмд чиглэсэн ямар томоохон ажлууд хийж**

**амжуулав аа?**  
Бид төрийн бус байгууллага байгуулсны дараа гишүүнчлэлээ өргөжүүлж, тэдний холбоо харилцааг сэргээх, бизнесийг нь холбож өгөх зэрэг олон талын үйл ажиллагаанууд зохион байгуулсанаас гадна дунд сургуулийн ахлах ангийн хөвгүүдэд эх оронч үзэл, хүмүүжил, цэргийн алба, цэргийн амьдралын талаар сургалтууд зохион байгууллаа. Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнд нэгдэж, Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд холбооны нэрэмжит төгөл бий болгосон. Холбоо улам өргөжин тэлж байгаа болохоор ирэх намар Бага дарга, Жагсаалын дарга

нарын чуулга уулзалтыг зохион байгуулж, зорилго зорилтоо тодорхойлж, Удирдах зөвлөлөө шинэчилж, цаашид хийх үйл ажиллагаагаа төлөвлөх зэргээр бодсон ажил их байна. **Та цэргийн алба хааж байсан үеэ энэ дашрамд дурсан санаач.**  
Би 1984-1987 онд Ховдын хороо буюу Хатанбаатар Магсаржавын нэрэмжит Ардын Армийн 123 дугаар Мотобуудлагын хороонд явган цэрэг байлаа. Явган цэрэг бол холбоо, хими, их буу зэрэг төрөл мэргэжлийн цэрэг шиг танхимд суугаад байдаггүй. "Гараад жагс" командар буу зэвсгээ агаад л гарна, жагсана, буудлага хийнэ, цэргийн хэргийн мэдлэгт суралцана, окоп ухна, марш

тактикийн тэмцээнд гүйнэ. Цэргийн албанд анх очсон өдрөөс хойш 40 шахам жил өнгөрсөн ч цэргийн андууд бид насан туршийн нөхөрлөлийн холбоотой болжээ. Хааяа уулзахаараа цэргийн алба хааж байсан үеэ дурсан хөгжилдөж, зарим нь бүр үйл явдлыг цаг агаар, хамт байлцсан хүмүүс, өдөр судар, бараг цаг минуттай нь ярьдаг. Ховдын хороонхон Баатар хайрхныг мөн ч их тойрч гүйсэн дээ. Сайхан дурсамж ч олон бий. Хал цэрэгт байхдаа бид Армийн марш тактикийн тэмцээнд гүйсэн нь бараг анхны бөгөөд эцсийн тохиолдол байх шүү. Бидний хувьд жаахан дургүйхэн байсан ч ангийн захирагч маань "За, онжавууд

аа. Та бүхэн сүүлчийн удаа тэмцээндээ гүйх гэж байна. Бүх бэлтгэлийг тань хангалаа. Та бүхэн надаас юу хүсэж байна" гэж билээ. Бид "Би чамд хайртай" киног үзмээр байна гэсэн. Нийслэлд дөнгөж нээлтээ хийсэн, Ховдод ч гараагүй байсан тэр киног цэргийн хуаранд маань авчирч үзүүлж байлаа. 20-иодхон настай залуучууд бид хөөрөөд л, зоригжоод л тэмцээндээ орж түрүүлснээр хошой аварга болж билээ. Хурандаа ч, бид ч хэлсэндээ хүрсэн. Би алба хаах хугацаандаа герман хэл судалж, цэргээс халагдаад их дээд сургуульд хоёр хүүдээ, залуус дүү нартаа хүн байхын утга учрыг танихын чухлыг ойлгуулахыг хичээдэг дээ.